150

**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 20 өдөр Дугаар А/147 Номгон

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангах тухай

"Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 60 дугаар зүйлийн 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн "Орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашинуудыг татан төвлөрүүлэх, доод үнэ тогтоох, дуудлагаар худалдах, акталж данснаас хасах, хэрэгцээт байгууллагуудад балансаас балансад шилжүүлэх тухай" 10/45 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан татан төвлөрүүлсэн суудлын автомашины дуудлагын худалдааны доод үнийг нэгдүгээр хавсралтаар, акталж, данснаас хасах суудлын автомашиныг хоёрдугаар хавсралтаар, балансаас балансад шилжүүлэх суудлын автомашиныг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Идэрмөнх)-д дор дурдсан арга хэмжээ авч, ажиллахыг үүрэг болгосугай.

2.1.Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн $11^{00}$ цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 103 тоот өрөөнд зохион байгуулж, орлогыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх.

2.2.Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх.

2.3.Энэ захирамжийн биелэлтийг 2023 оны 06 дугаар сард багтаан аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлэх.

842310261

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын
20 ны өдрийн А/147 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

## ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| № | Сум, дүүрэг | Ашиглагч байгууллагын нэр | Автомашины нэр | Улсын бүртгэлийн | | Дуудлагаар худалдах доод үнэ | Үйлдвэрлэсэн он | Дансны анхны үнэ | Элэгдэл | Үлдэх өртөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сери | Дугаар | | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 1 | Баянхонгор | Аймгийн ЗДТГазар | Hummer | БНР | 04-44 | 11,000,000 | 2006 | 39,000,000 | 27,950,000 | 11,050,000 |
| 2 | Баянхонгор | Аймгийн ЗДТГазар | Caravan | БНХ | 99-02 | 8,000,000 | 2008 | 45,110,000 | 31,952,917 | 13,157,083 |
| 3 | Баянхонгор | Статистикийн хэлтэс | Lexus-470 | БНХ | 17-01 | 5,000,000 | 2000 | 40,000,000 | 40,000,000 | 0 |
| 4 | Баянцагаан | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | Фургон /УАЗ-220692-033/ | БНХ | 53-28 | 6,000,000 | 2012 | 5,000,000 | 833,333 | 4,166,667 |
| 5 | Баянцагаан | Эрүүл мэндийн төв | УАЗ2206920 | БНА | 46-55 | 10,000,000 | 2017 | 29,736,434 | 26,019,380 | 3,717,054 |
| 6 | Бөмбөгөр | Засаг даргын Тамгын газар | Lexus-470 | УНГ | 30-23 | 10,000,000 | 2003 | 30,000,000 | 24,000,000 | 6,000,000 |
| 7 | Бөмбөгөр | Соёлын төв | Хуандай Старех | БНА | 46-14 | 5,000,000 | 2007 | 28,000,000 | 6,720,000 | 21,280,000 |
| 8 | Бөмбөгөр | Ерөнхий боловсролын сургууль | Хуандай Старех | БНА | 46-24 | 5,000,000 | 2004 | 18,000,000 | 11,250,000 | 6,750,000 |
| 9 | Бууцагаан | Засаг даргын Тамгын газар | Уаз фурган | БНА | 35-51 | 10,000,000 | 2017 | 31,000,000 | 25,833,333 | 5,166,667 |
| 10 | Галуут | Засаг даргын Тамгын газар | УАЗ Пургон | БНХ | 65-67 | 7,000,000 | 2014 | 32,250,000 | 32,250,000 | 0 |
| 11 | Галуут | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | Ланд 105 авто машин | БНА | 00-54 | 10,000,000 | 2007 | 47,000,000 | 40,285,714 | 6,714,286 |
| 12 | Баянхонгор | Орон нутгийн өмчийн газар | Ланд-100 | БНХ | 71-53 | 10,000,000 | 2015 | 40,000,000 | 40,000,000 | 0 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Баянхонгор | Боловсрол, соёл, урлагын газар | KNA КАРНИВАЛ Маркаар /он/ | БНН | 01-51 | 5,000,000 | 2006 | 9,000,000 | 9,000,000 | 0 |
| 14 | Баянхонгор | Зооноз өвчин судлалын төв | Пургон | БНА | 88-80 | 5,000,000 | 2009 | 15,200,000 | 15,200,000 | 0 |
| 15 | Баянхонгор | Эрүүл мэндийн газар | toyota landcruiser-76 | БНХ | 67-25 | 15,000,000 | 2010 | 56,471,297 | 56,471,297 | 0 |
| 16 | Баянхонгор | Төр нийгмийн зүтгэлтэн Сономын Лувсанвандангийн нэрэмжит Аймгийн хөгжимт драмын театр | Alphard | БНР | 14-84 | 8,000,000 | 2005 | 9,500,000 | 3,166,667 | 6,333,333 |
| 17 | Жинст | Засаг даргын Тамгын газар | Lexus-470 | БНХ | 80-11 | 7,000,000 | 2006 | 35,000,000 | 28,000,000 | 7,000,000 |
| 18 | Өлзийт | Ерөнхий боловсролын сургууль | TOYOTA hiace маркийн микробус | БНХ | 47-34 | 5,000,000 | 2007 | 23,500,000 | 23,500,000 | 0 |
| 19 | Өлзийт | Соёлын төв | УАЗ-фургон | БНХ | 41-85 | 8,000,000 | 2015 | 17,354,167 | 9,984,722 | 7,369,444 |
| 20 | Гурванбулаг | ИТХурал | Пажеро | БНХ | 24-00 | 5,000,000 | 1999 | 12,000,000 | 12,000,000 | - |
| **Нийт** | | | | | | **155,000,000** | | | | |

__________oOo____________

153

Аймгийн засаг даргын 2023 оны 03 дугаар
20 ны өдрийн А/[illegible] дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

## АКТЛАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| № | Сум, дүүрэг | Ашиглагч байгууллагын нэр | Автомашины нэр | Улсын бүртгэлийн | | Үйлдвэрлэсэн он | Дансны анхны үнэ | Элэгдэл | Үлдэх өртөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сери | Дугаар | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Баянцагаан | Засаг даргын Тамгын газар | UAZ390942-018 | БНХ | 27-91 | 2012 | 19,990,000 | 19,990,000 | 0 |
| 2 | Баацагаан | Ерөнхий боловсролын сургууль | Пургон | БНА | 27-53 | 2017 | 30,836,434 | 30,836,434 | 0 |
| 3 | Баянхонгор | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Lexus-470 | БНА | 26-13 | 2006 | 88,644,000 | 88,644,000 | 0 |
| 4 | Галуут | Засаг даргын Тамгын газар | УАЗ 469 | БНА | 95-58 | 2009 | 17,300,000 | 17,300,000 | 0 |
| 5 | Галуут | Засаг даргын Тамгын газар | Хагас пургон | БНХ | 37-58 | 2010 | 19,990,000 | 19,990,000 | 0 |
| 6 | Баянхонгор | Нэгдсэн эмнэлэг | Ниссан | БНХ | 01-13 | 2002 | 30,000,000 | 30,000,000 | 0 |

oOo

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 20 ны өдрийн А/147 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

## БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| № | Сум, дүүрэг | Ашиглагч байгууллагын нэр | Автомашины нэр | Улсын бүртгэлийн Сери | Улсын бүртгэлийн Дугаар | Үйлдвэр-лэсэн он | Дансны анхны үнэ | Элэгдэл | Үлдэх өртөг | Шилжүүлэх байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 1 | Баян-Өндөр | Засаг даргын Тамгын газар | toyota Succeed-XP50 | БНН | 19-76 | 2006 | 7,400,000 | 2,960,000 | 4,440,000 | Аймгийн цагдаагийн газарт |
| 2 | Баянцагаан | здтг | соната | БНХ | 32-60 | 2006 | 3,000,000 | 1,800,000 | 1,200,000 | Аймгийн цагдаагийн газарт |
| 3 | Баянцагаан | Соёлын төв | Toyota Hiaci | БНХ | 05-18 | 2007 | 24,000,000 | 12,000,000 | 12,000,000 | Баянцагаан сумын ЗДТГ |
| 4 | Бөмбөгөр | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | УАЗ фургон | БНА | 27-32 | 2014 | 30,000,000 | 30,000,000 | - | Аймгийн цагдаагийн газарт |
| 5 | Бууцагаан | Соёлын төв | Toyota Haice | БНА | 02-54 | 2009 | 24,000,000 | 12000000 | 12,000,000 | Бууцагаан сумын ЗДТГ |
| 6 | Баянбулаг | Засаг даргын Тамгын газар | Toyota probox | БНХ | 00-46 | 2004 | 6,160,000 | 3,285,333 | 2,874,667 | Аймгийн цагдаагийн газарт |
| 7 | Галуут | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | Ланд 105 авто машин | БНА | 38-37 | 2006 | 34,800,000 | 6,960,000 | 27,840,000 | Галуут сумын ЗДТГ |
| 8 | Галуут | Ерөнхий боловсролын сургууль | УАЗ-Пургон автомашин | БНХ | 18-81 | 2017 | 28,000,000 | 7,840,000 | 20,160,000 | Галуут сумын ЗДТГ |
| 9 | Баян-Овоо | Засаг даргын Тамгын газар | Цагдаагийн машин /румон/ | УБА | 73-80 | | 10,000,000 | 6,600,000 | 3,400,000 | Аймгийн цагдаагийн газарт |
| 10 | Өлзийт | Засаг даргын Тамгын газар | Probox | БНА | 01-30 | 2013 | 10,000,000 | 8,000,000 | 2,000,000 | Аймгийн цагдаагийн газарт |

___________oOo___________

15.2.2.Хэрэгжүүлэхээр санал болгож буй уралдаант шалгаруулалтын үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөний чанар, хувьчлалын зорилго, зарчмын шаардлагыг хүлээн авч тусгасан байдал (0-50 оноо)

15.2.3.Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөний чанар, ажиллагсдад учрах эрсдэлийг багасгах арга хэмжээ (0-10 оноо)

15.3.Тендерийн саналыг үнэлэх үзүүлэлтүүд , ногдуулах онооны системийг тухайн байгууллагын хувьчлалыг зарлах үед байгууллага тус бүр дээр энэхүү журмын 15.2-д заасныг үндэслэн тусгайлан тогтооно.

15.4.Тендерийн саналын үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан тендерт оролцогч нь ялагч болно.

15.5.Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагаа дууссаны дараа тендерийн комисс нь тендерийн үнэлгээний тайлан бичнэ.

15.6.Тендерийн үнэлгээний комисс нь тендерийн үнэлгээний тайланг тендерийн хорооны хуралдаанд оруулан хэлэлцүүлнэ. Тендерийн хорооны хуралдаанаас үнэлгээний тайланг үндэслэлтэй гэж үзвэл батлах, үндэслэлгүй болон хууль зөрчсөн гэж үзвэл дахиж шинжилгээ хийх шийдвэрийн аль нэгийг гаргана. Тендерийн хорооны хуралдааны шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг дарга эцсийн шийдвэрийг гаргана.

15.7.Тендерийн хорооны хуралдааны шийдвэрийг баталсны дараа тендерийн ялагчтай байгуулах "Уралдаант шалгаруулалтын үр дүнг харгалзан хувчлах гэрээ"-д аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга гарын үзэг зурна.

## Арван зургаа. Тендерийг явагдаагүйд болон хүчингүйд тооцох төслийн санал ирүүлэх хугацааг сунгах

16.1.Тендерийг явагдаагүйд болон хүчингүйд тооцох, тендерийн санал ирүүлэх хугацааг сунгах тухай шийдвэрийг Тендерийн комиссын хуралдаанаар шийдвэрлэнэ.

16.2.Тендерт оролцох тухай төсөл ирээгүй тохиолдолд тендерийг явагдаагүйд тооцно.

Дараах тохиолдолд тендерийг хүчингүйд тооцно. Үүнд:

16.3.Нэг ч тендерийн санал тендерийн комиссын үнэлгээгээр шаардлага хангаагүй

16.4.Өргөдөл, тендерийн санал ирүүлэх хугацааг сунгасан, тендерийн хуваарийг өөрчилсөн тухай болон тендерийн журамд өөрчлөлт оруулах шаардлага гарвал Орон нутгийн өмчийн газар энэ тухай бүх оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

**Арван долоо. Маргааныг шийдвэрлэх**

17.1.Тендертэй холбоотой гарсан аливаа гомдол, маргааныг аймгийн Засаг дарга холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

17.2.Гомдол, маргаан гаргагч нь Засаг даргын шийдвэрийг эс зөвшөөрвөл зохих шатны шүүхэд хандаж болно.

Энэ журмыг хүлээн зөвшөөрсөн тендерт
оролцогчийн гарын үсэг (                    )

.......... оны ..........сарын .........-ний өдөр

Аймгийн Засаг даргын 2023 оны 3...дугаар сарын
06.-ны өдрийн А/126 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

# БАЯНХОНГОР ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭЛТЭЙ ЗАМ ТАЛБАЙН ХАВТАН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ИЖ БҮРЭН АВТОМАТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ХУВЬЧЛАХ УРАЛДААНТ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 06 Номгон

| | |
|---|---|
| 1.Үндсэн нөхцөл | • Хөрөнгө оруулж үндсэн ажил, үйлчилгээний зориулалтыг өөрчлөхгүйгээр технологийг шинэчлэх замаар хувьчлагдах хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашгийг нь дээшлүүлэх,<br>• Тус байгууламжийн өртгийг орон нутгийн орлогын дансанд 3 жилийн хугацаанд хуваарийн дагуу эргэн төлөх<br>• Сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан<br>• Санхүү, техник, боловсон хүчний бүрэн чадавхтай байх<br>• Явган хүний зам, талбайн төлөвлөлт техникийн шаардлага MNS 6808 2019 стандартыг мөрдлөг болгон ажиллах, барилга, тоног төхөөрөмжид хийх шинэчлэл, засварыг өөрийн хөрөнгөөр хийнэ.<br>• Үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ажиллах<br>• Явган хүний зам, талбайн хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон борлуулалтын нэг бүрийн үнэ тооцоо<br>• Тендерт оролцогч нь эргэн төлөлтийн хуваарийг сар, улирал, бүтэн жилээр нарийвчлан тооцож ирүүлэх |
| 2.Тоног төхөөрөмжийн зориулалт ашиглалт | • Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг бүрэн хариуцаж засварлах, хэвийн ажиллагааг хангах<br>• Тоног төхөөрөмж нь ашиглалтын буруугаас үүдэн гарах аливаа эрсдэлийг бүрэн хариуцах, урсгал засвар арчилгааг цаг тухай бүрд нь хийдэг байх |
| 3.Онцгой нөхцөл | • Явган хүний зам, талбайн төлөвлөлт техникийн шаардлага MNS 6808 2019 стандартыг баримтлах, зайлшгүй тохиолдолд төр захиргааны байгууллагатай хамтран өөрчлөх, өргөтгөх, шинэ технологи эзэмших сайжруулах |

__________оОо__________

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 06.-ны өдрийн А/126 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

**БАЯНХОНГОР ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭЛТЭЙ ЗАМ ТАЛБАЙН ХАВТАН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ИЖ БҮРЭН АВТОМАТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ УРАЛДААНТ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА,ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

2023 оны 03 дугаар сарын 06 Номгон

1.Сонгон шалгаруулалтын ерөнхий нөхцөл

| | |
|---|---|
| Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа | 2023 оны 05 р сарын 23-ны өдөр |
| Материал нээх хугацаа, хаяг байршил | Нутгийн удирдлагын ордны 1 давхар 117 тоот өрөө |
| Аж ахуй нэгжийн мэдээлэл | Хувь хүн, хуулийн этгээдийн ерөнхий танилцуулга ирүүлэх |
| Зам талбайн хавтан үйлдвэрлэлийн барилга, байгууламж, иж бүрэн автомат тоног төхөөрөмжийг уралдаант сонгон шалгаруулалтад тавигдах ерөнхий шаардлага | 1.Монгол улсын болон гадаадын дор дурдсанаас бусад хувийн өмчийн хуулийн этгээд, хувь хүн тендерт оролцож болно.<br>а/Төрийн байгууллага, албан газар<br>б/Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд<br>в/Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд<br>г/ Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн бус байгууллага<br>2.Хуулийн этгээд, хувь хүн дангаараа эсвэл хамтарсан хэлбэрээр тендерт оролцож болно. Хамтарсан хэлбэрээр тендерт оролцох тохиолдолд тэдгээрийн хооронд “Тендерт хамтран оролцох тухай гэрээ” байгуулсан байна.<br>3.Тендерт оролцогч өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж болно. Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон тохиолдолд түүний төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна.<br>4.Явган хүний зам, талбайн төлөвлөлт техникийн шаардлага MNS 6808 2019 стандартыг мөрдлөг болгон ажиллах, барилга, тоног төхөөрөмжид хийх шинэчлэл, засварыг өөрийн хөрөнгөөр хийнэ.<br>5.Хэд хэдэн хуулийн этгээд, хувь хүн тендерт хамтран оролцож байгаа бол тэд зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.<br>6.Төрийн албан хаагч эрхэлж буй албан тушаалын нэрийн өмнөөс тендерт оролцож болохгүй.<br>7.Хөрөнгө оруулж үндсэн ажил, үйлчилгээний зориулалтыг өөрчлөхгүйгээр технологийг шинэчлэх замаар хувьчлагдах хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашгийг нь дээшлүүлэх,<br>8.Тус байгууламжийн өртгийг орон нутгийн орлогын дансанд 3 жилийн хугацаанд хуваарийн дагуу эргэн төлөх<br>9.Тендерт оролцогч нь эргэн төлөлтийн хуваарийг сар, улирал, бүтэн жилээр нарийвчлан тооцож ирүүлэх<br>10.Санхүү, техник, боловсон хүчний бүрэн чадавхтай |

| 1 | 2 |
|---|---|
| | байх<br>11.Худалдах доод үнэ 385,000,000 төгрөг |
| Ирүүлэх материал | 1. Өргөдөл<br>2. Монгол банк, Татвар, Шүүх, ШШГГ-ын тодорхойлолт эх хувь<br>3. Сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан<br>4. Монгол банк, Татвар, Шүүх, ШШГГ-ын тодорхойлолт эх хувь<br>5. Тендерт оролцохыг хүссэн хуулийн этгээдийг үүсгэн байгуулж бүртгүүлсэн тухай баримт бичгүүд /гэрээ, дүрэм, гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар/, хувь хүн бол иргэний үнэмлэхийг нотариатаар баталгаажуулсан хуулбар<br>6. Уралдаант шалгаруулалтын багийн ахлагч, гишүүдийн анкет, тэдгээрийн ажлын туршлагын тухай дэлгэрэнгүй танилцуулга, боловсрол, мэргэжлийн диплом болон эрдмийн зэрэг, цолны гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, эрдэм шинжилгээний ажил, эрдмийн бүтээлийн жагсаалт<br>7. Тендерт хамтарсан хэлбэрээр оролцох тохиолдолд хамтрагчдын хооронд байгуулсан "Тендерт хамтран оролцох тухай гэрээ"<br>8. Тендерийн дэнчингийн Төрийн сан банкин дах Орон нутгийн өмчийн газрын 100030051006 дансанд шилжүүлсэн баримт<br>9. Чадварын мэдээлэл /Туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг<br>10.Явган хүний зам, талбайн хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон борлуулалтын нэг бүрийн үнэ тооцоо<br>11.Худалдан авах үнийн санал битүүмжлэн ирүүлнэ. |

2.Сонгон шалгаруулалтын материалыг дүгнэх маягт

| № | Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр | Материалын бүрдэл (40 оноо) | Туршлага (10 оноо) | Ажиллах хүчний чадвар (10 оноо) | Санхүүгийн чадвар (10 оноо) | Үнийн санал (30 оноо) | Нийт оноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |

Хаяг: Нутгийн удирдлагын ордны 1 давхар 117 тоот өрөө

Утас: 99062997, 88448333, 99694733

___________oOo___________

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Дуу тусгаарлагч эсгий хавтан | М | 3 | 140.000 | 420.000 | Эсгий хавтангаар газрын зураг бүхий дүрс хийж тэмдэглэл хийж, өрөөг тохижуулах |
| **Нийт дүн** | | | **3.000.000** | | | |

________o0o ________